



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 2/43

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, ОХУ-ын Эрхүү хот дахь Сибирь, Алс Дорнодын тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэн болон Эрүүл мэндийн яамны харьяа Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн хооронд байгуулсан гэрээ, Төвийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумдын хил орчмын бүс нутагт хийх тарваган тахал, хам тохиолдох өвчний хамтарсан тандалт судалгаа”-ны ажлыг удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Паразитологич (Ж.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

2. “Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумдын хил орчмын бүс нутагт хийх тарваган тахал, хам тохиолдох өвчний хамтарсан тандалт судалгаа”-ны зардал болох 7,008,500 (долоон сая найман мянга таван зуун) төгрөгийг томилолт, тээвэр, шатахуун, холбогдох зардлаас тооцож гаргахыг ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. “Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумдын хил орчмын бүс нутагт хийх тарваган тахал, хам тохиолдох өвчний хамтарсан тандалт судалгаа”-нд ажиллах мэргэжилтнийг томилж удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (Л.Роломжав)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанар, аюулгүй байдал, хяналт-үнэлгээний алба (У.Нармандах)-нд даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

1813111098